



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 19 (304)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай*
- *Улсын тэмдэгтийн хураамжийн хуульд өөрчлөлт оруулах тухай*
- *Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*
- *Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2003 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2003 оны тавдугаар сарын 21

№ 19 (34)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

278.	Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай	(2003-5-2-ны хууль)	441
279.	Барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	(2003-5-2-ны хууль)	449
280.	Улсын тэмдэгтийн хураамжийн хуульд өөрчлөлт оруулах тухай	(2003-5-2-ны хууль)	450
281.	Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	(2003-5-2-ны хууль)	450
282.	Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай	(2003-5-2-ны хууль)	450

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

283.	Амьсгалын цочмог халтай хамшинж өвчний цагийн байдалтай холбогдуулан авах арга арга хэмжээний тухай	Дугаар 102	450
284.	Аргачлал, үнэлгээ батлах тухай	Дугаар 103	451

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

БАРААНЫ ТЭМДЭГ, ГАЗАР ЗҮЙН ЗААЛТЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

зарцуулах, газар зүйн заалтыг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Нийтлэг үндэслэл

2 дугаар зүйл. Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль тогтоомж

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь бараа, үйлчилгээний тэмдэг /цаашид "барааны тэмдэг" гэх/, газар зүйн заалтыг эрх зүйн хувьд баталгаажуулах, түүнийг эзэмшигч, хэрэглэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, барааны тэмдэг эзэмших, ашиглах, захиран

2.1. Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Иргэний хууль², энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

¹ Монгол Улсын Үндсэн хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

² Иргэний хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд засаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний залтыг дагах мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дордурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "барааны тэмдэг" гэж үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг иргэн, хуулийн этгээд өөрийн брээ, үйлчилгээг бусдын бараа, үйлчилгээгээс ялгах зэмлэгээр хэрэглэх ялгагдах чадвартай илэрхийллийг;

3.1.2. "хамтын тэмдэг" гэж үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид нэгдсэн хяналтын дор ашиглах брэаны тэмдгийг;

3.1.3. "гэрчлэх тэмдэг" гэж тухайн бараа, үйлчилгээний чанар, үйлдвэрлэх арга, бусад онцлог шинж чанарыг тэмдэг эзэмшигч гэрчлэн бусад этгээдэд ашиглуулах барааны тэмдгийг;

3.1.4. "газар зүйн заалт" гэж тухайн барааны чанар, нэр хүнд, онцлог бусад шинж чанар нь түүний газар зүйн гарал үүсэлтэй салшгүй холбоотойг илэрхийлсэн, тус барааг үйлдвэрлэсэн улс, бүс, газар нутгийн газар зүйн нэрийг;

3.1.5. "бүртгэгдсэн тэмдэг, газар зүйн заалт" гэж оюуны өмчийн байгууллага хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгосон брэаны тэмдэг, газар зүйн заалтыг;

3.1.6. "гэрчилгээ" гэж улсын бүртгэлд бүртгэгдсэн барааны тэмдэг эзэмшигч, газар зүйн заалт эрхлэгчийн онцгой эрхийг зөвшөөрч, төрөөс олгож байгаа баримт бичгийг;

3.1.7. "барааны тэмдэг эзэмшигч" гэж бүртгэгдсэн тэмдгийг эзэмших, ашиглах, захиран ариуулах эрхийг хуульд заасан журмын дагуу олж авсан этгээдийг;

3.1.8. "газар зүйн заалт хэрэглэгч" гэж газар зүйн заалтыг өөрийн бараанд ашиглах эрхийг хуульд заасан журмын дагуу олж авсан этгээдийг;

3.1.9. "мэдүүлэг" гэж барааны тэмдэг, газар зүйн заалтыг бүртгүүлэхийг хүссэн иргэн, хуулийн этгээдээс оюуны өмчийн байгууллагад гаргаж байгаа өргөдөл, хуульд заасан бусад баримт бичгийг;

3.1.10. "шүүлт" гэж тухайн барааны тэмдэг, газар зүйн заалт энэ хуульд заасан шаардлага хангасан сэх, тэдгээртэй ижил төстэй тэмдэг, газар зүйн заалт мөн нь бүртгэгдсэн эсэх талаар оюуны өмчийн хайгууллагийн эрх бүхий шинэчлэлийн хийх магадлагааг;

3.1.11. "нийтэд түгээмэл болсон тэмдэг" гэж Лонгол Улсын нутаг дэвсгэр дээр тухайн салбарт нийтэд танил болсон тэмдгийг;

3.1.12. "лиценз" гэж барааны тэмдэг эзэмшигч

бүртгэгдсэн тэмдгээ бусдад ашиглуулахаар өгсөн зөвшөөрлийг;

3.1.13. "анхдагч огноо" гэж энэ хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу барааны тэмдгийн мэдүүлгийг оюуны өмчийн байгууллагад анх өгсөн он, сар, өдрийг;

3.1.14. "давамгайлах огноо" гэж барааны тэмдгийг Парисын конвенцийн гишүүн болон Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн аль нэг оронд бүртгүүлэхээр өгсөн, эсхүл уг конвенцийн 4 дүгээр зүйлд заасны дагуу давуу эрх авахыг хүссэн он, сар, өдрийг;

3.1.15. "олон улсын ангилал" гэж 1957 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн Нийцлийн хэлэлцээрээр баталсан "Барааны тэмдэг бүртгэхэд ашиглах бараа, үйлчилгээний олон улсын ангилал"-ыг;

3.1.16. "барааны тэмдгийн олон улсын бүртгэл" гэж Дэлхийн оюуны өмчийн байгууллагын Мадридын хэлэлцээр, Мадридын Протоколын дагуу Олон улсын төвчооны гүйцэтгэгч бүртгэлийг;

3.1.17. "Парисын конвенци" гэж 1883 оны 3 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан, нэмэлт, өөрчлөлт оруулж хянан засварласан Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцийг;

3.1.18. "Мадридын хэлэлцээр" гэж 1891 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр байгуулсан, нэмэлт, өөрчлөлт оруулж хянан засварласан Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээрийг;

3.1.19. "Мадридын Протокол" гэж 1989 оны 6 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээрийн Протоколыг;

3.1.20. "Мадридын хэлэлцээр болон Мадридын Протоколын журам" гэж уг Хэлэлцээр болон Протоколын 2002 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон Нийтлэг журмыг.

4 дүгээр зүйл. Барааны тэмдэг, газар зүйн заалтын талаархи оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

4.1. Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь "байгууллага" гэх нь барааны тэмдэг, газар зүйн заалтыг бүртгэхтэй холбогдсон дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.1.1. барааны тэмдэг, газар зүйн заалтын мэдүүлгийг хүлээн авч, хянан шийдвэрлэх;

4.1.2. барааны тэмдэг, газар зүйн заалтыг бүртгэж, гэрчилгээ олгох;

4.1.3. барааны тэмдэг, газар зүйн заалтын талаархи маргааныг шүүхээр хянан шийдвэрлэхэд лавлагаа өгөх;

4.1.4. хуулиар харьяалуулсан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх;

4.1.5. барааны тэмдэг, газар зүйн заалтын гэрчилгээний загварыг тогтоох;

4.1.6. барааны тэмдэг, түүнтэй холбоотой гэрээ, газар зүйн заалтын улсын нэгдсэн бүртгэл хөтөлж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, тэдгээртэй холбоотой мэдээллийг хөвлэн нийтлэх;

4.1.7. хуульд заасан үндэслэл, журмын дагуу барааны тэмдэг, газар зүйн заалтыг хүчингүй болсонд тооцох;

4.1.8. хуульд заасан бусад чиг үүрэг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Барааны тэмдэг, түүнийг бүртгэх, гэрчилгээ олгох

5 дугаар зүйл. Барааны тэмдгээр бүртгүүлэх зүйл, түүнд тавих шаардлага

5.1. Барааны тэмдэг нь үг, дүрс, үсэг, тоо, гурван хэмжээст дүрс, өнгө, дуу авиа, үнэр, эсхүл тэдгээрийг хосолсон байдлаар илэрхийлэгдэж болно.

5.2. Дараахь зүйлийг барааны тэмдэгт тооцохгүй:

5.2.1. нийтэд дэлгэрсэн нэр томъёо, дүрс, үл ялгагдах үсэг, тоо, тэмдэгт;

5.2.2. бараа, үйлчилгээний үндсэн нэр, барааны тоо, хэмжээ, жин, чанар, зориулалт, үнэ, үйлдвэрлэсэн газрын нэр, арга, хугацаа зэргийг тайлбарласан үг, дүрс;

5.2.3. барааны гаднах хэв маяг, сав, баглаа боодлын өрдийн хэлбэр;

5.2.4. газрын зураг болон газрын зураг дээр заасан байрлал;

5.3. Дараахь зүйлийг барааны тэмдгээр бүртгэхгүй:

5.3.1. Монгол Улсын болон гадаад улсын сүлд, далбаа, төрийн бэлгэдэл, төрийн болон төрийн бус, түүнчлэн олон улсын байгууллагын бүтэн ба товчилсон нэр, албан ёсны тэмдэгт бүрдсэн, эсхүл тэдгээртэй ижил буюу төсөөтэй бол;

5.3.2. нэрд гарсан хүний бүтэн ба товчилсон нэр, хөрөг, зураг, гарын үсгийг тухайн хүний буюу түүний өв залгамжлагчийн зөвшөөрөлгүйгээр ашигласан бол;

5.3.3. Монгол Улсын түүхэн хүмүүсийн нэр, зохиомол нэр, хөрөг, зураг, тэдгээрт шууд хамаарах төсөөллийн нэрийг гутаах байдлаар ашигласан бол;

5.3.4. Монгол Улсын түүх, соёлын дурсгалт зүйлийн нэр, дүрсийг гутаах байдлаар ашигласан бол;

5.3.5. төрийн одон, медаль болон бусад шагнал, баталгаа, хяналтын албан ёсны тэмдэг, дардастай ижил буюу төсөөтэй бол;

5.3.6. агуулга нь нийгмийн дэг журам, зан суртахуунд харш бол;

5.3.7. бараа, үйлчилгээний чанар, чансаа, гарал үүсэл болон бусад шинж чанарын хувьд хэрэглэгчийг төвөгдөлд оруулж болзошгүй буюу худал зүйл бол.

5.4. Дараахь барааны тэмдгийг бүртгэхгүй

5.4.1. Монгол Улсад бүртгэгдсэн буюу бүртгүүлэхээр мэдүүлсэн адил бараа, үйлчилгээнд хэрэглэх барааны тэмдэгтэй ижил бол;

5.4.2. Монгол Улсад бүртгэгдсэн буюу бүртгүүлэхээр мэдүүлсэн нэг төрлийн бараа, үйлчилгээнд хэрэглэх барааны тэмдэгтэй ижил буюу төсөөтэйгээс хэрэглэгчийг төвөгдөлд оруулж болзошгүй бол;

5.4.3. бараа, үйлчилгээний төрөл, бүртгэгдсэн эсэхээс үл хамаарч нийтэд түгээмэл болсон барааны тэмдэгтэй ижил буюу төсөөтэйгээс хэрэглэгчийг төвөгдөлд оруулах, шударга бус давуу эрх эдлэх, ашиг олох, хохирол учруулах, нэр хүндийг гутаахаар бол;

5.4.4. бусдын зохиогчийн эрх буюу эрх үйлдвэрийн өмчийн эрхтэй зөрчилдөхөөр бол.

6 дугаар зүйл. Барааны тэмдгийн мэдүүлэг гаргах

6.1. Барааны тэмдгийг бүртгүүлэх хүсэлтэй иргэн, хуулийн этгээд барааны тэмдгийн мэдүүлэг /цаашид "мэдүүлэг" гэх/-ийг оюуны өмчийн байгууллагад монгол хэлээр гаргах бөгөөд мэдүүлэг дараахь зүйлийг тусгана:

6.1.1. барааны тэмдэг бүртгүүлэх тухай хүсэлт;

6.1.2. мэдүүлэг гаргагчийн овог, эцэг эх/-ийн нэр, өөрийн нэр, хаяг, харьяалал, байнга оршин суудаг буюу үйл ажиллагаа явуулдаг улсын нэр мэдүүлэг гаргасан он, сар, өдөр;

6.1.3. мэдүүлэг гаргагч нь хуулийн этгээд бол түүний оноосон нэр, хаяг, зохион байгуулалтын хэлбэр, тэмдэг, эрх бүхий албан тушаалтны гарын үсэг;

6.1.4. мэдүүлэг гаргагч итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй байвал түүний овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хаяг, мэдүүлэг гаргагч буюу итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гарын үсэг;

6.1.5. дэвэмгайлах огноо хүсэх тохиолдолд урьд өмнө гаргаж байсан мэдүүлгийн тухай мэдэгдэл;

6.1.6. барааны тэмдгийг өнгө засаж буюу эзлэхүүний хэлбэрээр бүртгүүлэхийг хүсвэл энэ тухай

Мэдэгдэл

6.17 барааны тэмдэг нь хамтын буюу гэрлэх эгдэг байвал энэ тухай мэдэгдэл;

6.18 барааны тэмдгийн дүрс;

6.19 барааны тэмдэг нь кирилл, латинаас эер үсгээр илэрхийлэгдсэн бол тухайн тэмдгийн ирлэлтээр галигласан хөрвүүлэг, гадаад үзэр алархийлэгдсэн бол түүний орчуулга;

6.10 олон улсын ангиллын дагуу ангилсан үзэйн барааны тэмдэгт хамаарах бараа, үйлчилгээн нэр.

6.1 Мэдүүлэг нь зөвхөн нэг барааны тэмдэгт хамаара.

7 дугаар зүйл. Мэдүүлгийн анхдагч оноог тогтоох

7.1 Оюуны өмчийн байгууллага нь мэдүүлгийг хүлээн авсан өдрөөс хойш 20 хоногийн дотор түүний бүртгийг янзж энэ хуулийн 6.1-д заасан шаардлага хангасан эх үзвэл мэдүүлгийг хүлээн авсан өдрөөр анхдагч оноог тогтооно.

7.2 Оюуны өмчийн байгууллага мэдүүлгийг эсэргүүцэн 5.1-д заасан шаардлага хангаагүй гэж үзвэл 2 сарын дотор холбогдох нэмэлт, засвар хийхийг бичгээр мэдэгдэх бөгөөд энэ хугацаанд зохих нэмэлт, засвар хийж ирүүлсэн бол мэдүүлгийн анхдагч оноог түүний эх сүлжсэн авсан өдрөөр тогтооно.

7.3 Энэ хуулийн 7.2-т заасан хугацаанд нэмэлт засвар хийж ирүүлээгүй бол тухайн мэдүүлгийг оюуны өмчийн байгууллага хүлээн авсанд тооцогүй ба сүүлдээ хожимдуулж нэмэлт, засвар хийсэн бол шийдвэр мэдүүлэг гаргах журмын дагуу анхдагч оноог тогтооно.

7.4 Барааны тэмдэг бүртгүүлэхээр хүсэлт гаргасан эхлэн, хуулийн этгээд тухайн барааг албан ёсны үзэсгэлэнд тавьснаас хойш 6 сарын дотор мэдүүлэг гаргасан бол барааг үзэсгэлэнд тавьсан өдрөөр анхдагч оноог тогтоох бөгөөд үзэсгэлэнд орлолсон тухай нотлох баримтгүй мэдүүлэгтээ хясаархан байна.

8 дугаар зүйл. Мэдүүлэгт шүүлт хийх

8.1 Оюуны өмчийн байгууллага нь энэ хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу мэдүүлгийн анхдагч оноог тогтоосны дараа тухайн тэмдэг барааны тэмдэгт тохирдог эсэх бүртгэж болох эсэхэд шүүлт хийнэ.

8.2 Шүүлт хийх явцад мэдүүлэг гаргагч барааны тэмдгийг өөрчлөхөөс бусад өөрчлөлтийг мэдүүлэгтэй хийж болох бөгөөд бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш бараа, үйлчилгээний нэрсийн жагсаалтад нэмэлт хийх бол шинээр мэдүүлэг гаргана.

8.3 Шүүлт хийх явцад мэдүүлэг гаргагч нь бараа, үйлчилгээний нэгээс дээш ангилалд хамаарах мэдүүлгийг салгаж тус тусад нь гаргаж болно.

8.4 Оюуны өмчийн байгууллага нь мэдүүлгийн анхдагч онооноос хойш 12 сарын дотор шүүлтийн дүнгэлтэд үндэслэн барааны тэмдгийг бүртгэх эсэх талаар шийдвэр гаргах бөгөөд шаардлагатай гэж үзвэл энэ хугацааг 6 сар хүртэл хугацаагаар сунгаж болно.

8.5 Барааны тэмдэг нь энэ хуульд заасан шаардлага хангаагүй гэж үзвэл оюуны өмчийн байгууллага энэ талаар бичгээр мэдэгдэх бөгөөд мэдүүлэг гаргагч нь 3 сарын дотор үндэслэл бүхий хариу ирүүлээгүй бол барааны тэмдгийг бүртгэхээс татгалзах шийдвэр гаргана.

8.6 Оюуны өмчийн байгууллага нь барааны тэмдгийг бүртгэхээс татгалзсан бол мэдүүлэг, шүүлтийн дүнгэлтийн хуулбарыг уг шийдвэр гарсан өдрөөс хойш 1 сарын дотор мэдүүлэг гаргагчид хүргүүлнэ.

8.7 Мэдүүлэг гаргагч нь шинэсэнийн гаргасан шүүлтийн дүнгэлтийг эс зөвшөөрвөл гомдлоо барааны тэмдгийг бүртгэхээс татгалзсан тухай шийдвэр хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор оюуны өмчийн байгууллагад гаргаж болно.

9 дүгээр зүйл. Барааны тэмдгийг бүртгэх, гэрчилгээ олгох

9.1 Оюуны өмчийн байгууллага нь барааны тэмдгийг бүртгэх шийдвэр гаргасан бол түүнийг барааны тэмдгийн улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгож, мэдүүлгийг нь барааны тэмдгийн санд хадгална.

9.2 Барааны тэмдгийн улсын бүртгэл болон гэрчилгээнд түүнийг эзэмшигчийн овог, эцэг /дах/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээдийн оноосон нэр, хаяг, эрхэлдэг үйл ажиллагаа, барааны тэмдгийн дүрс, онцлог шинэ чанар, олон улсын ангиллын дагуу ангилсан тухайн барааны тэмдэгт хамаарах бараа, үйлчилгээний нэрсийн жагсаалт, мэдүүлгийн анхдагч оноо, гэрчилгээ хүчинтэй байх хугацааг заана.

9.3 Оюуны өмчийн байгууллага нь бүртгэгдсэн барааны тэмдгийн ном зүй, дүрсийг хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд нийлгэнэ.

10 дугаар зүйл. Барааны тэмдгийн бүртгэл хүчинтэй байх хугацаа, түүнийг сунгах

10.1 Барааны тэмдгийн бүртгэл нь анхдагч онооноос эхлэн 10 жилийн хугацаанд хүчинтэй байх бөгөөд эзэмшигчийн хүсэлтийг үндэслэн хугацааг тухай бүр 10 жилээр сунгаж болно.

10.2 Бүртгэлийн хүчинтэй байх хугацааг сунгуулах тухай хүсэлтийг тухайн бүртгэл хүчинтэй байх сүүлийн 1 жилд багтаан оюуны өмчийн байгууллагад гаргана.

10.3 Энэ хуулийн 10.2-т заасан хугацаанд бүртгэлийн хүчинтэй байх хугацааг сунгуулах тухай хүсэлт гаргаагүй бол бүртгэлийн хүчинтэй байх хугацаа дууссанаас хойш 6 сарын дотор хүсэлт гаргаж болно.

10.4 Бүртгэлийн хүчинтэй байх хугацааг сунгахад барааны тэмдгийг өөрчлөхгүй бөгөөд бараа, үйлчилгээний нэрсийн жагсаалтад нэмэлт хийхгүй.

10.5 Барааны тэмдэг эзэмшигчийн нэр, хаяг өөрчлөгдөх бүрт ийнхүү өөрчлөлт орсон өдрөөс хойш 6 сарын дотор оюуны өмчийн байгууллагад бичгээр мэдэгдэн улсын бүртгэлд өөрчлөлт хийлгэж, гэрчилгээг солиулна.

10.6 Барааны тэмдгийн бүртгэлийн хүчинтэй байх хугацааг сунгасан, эсхүл барааны тэмдгийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулсан бол оюуны өмчийн байгууллага энэ тухай хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд нийтлэнэ.

11 дүгээр зүйл. Барааны тэмдгийн бүртгэлийн хураамж

11.1 Барааны тэмдгийн гэрчилгээ олгох, бүртгэлийн хүчинтэй байх хугацааг сунгахад Улсын тэмдэгийн хураамжийн хуульд¹ заасан хувь хэмжээгээр хураамж төлнө.

11.2 Хураамжийг барааны тэмдгийн гэрчилгээ олгох, барааны тэмдгийн бүртгэлийн хүчинтэй байх хугацааг сунгах тухай шийдвэр гарсан өдрөөс хойш 3 сарын дотор төлнө.

12 дугаар зүйл. Хамтын тэмдэг

12.1 Тухайн барааны тэмдгийг хамтын тэмдгээр бүртгүүлэх хүсэлтэй этгээд хамтын тэмдгийн мэдүүлгийг энэ хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу гаргах бөгөөд түүнд дараахь зүйлийг хавсаргана:

12.1.1. хамтын тэмдгийг ашиглах журам;

12.1.2. хамтын тэмдгийг нэгдсэн хяналтын дор ашиглах үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн нэрсийн жагсаалт.

12.2 Хамтын тэмдгийг ашиглах журмд тухайн тэмдгийг ашиглахад хяналт тавих этгээдийн нэр, хаяг, зорилго, гишүүнээр элсэх нөхцөл, хамтын тэмдгийг ашиглах зорилго, нөхцөл, ашиглахад тавих шаардлага, хяналт, журмыг зөриж ашигласан тохиолдолд хүлээх хариуцлагыг тусгана.

12.3 Хамтын тэмдгийн эзэмшигч нь тухайн тэмдгийг ашиглахад хяналт тавих этгээд байх бөгөөд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч гишүүд нь хамтын тэмдгийг нэгдсэн хяналтын дор зөвхөн ашиглах эрхтэй байна.

12.4 Хамтын тэмдэг эзэмшигч болон ашиглагч нь уг тэмдгийг хууль бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах эрхтэй.

12.5 Хамтын тэмдэг эзэмшигч болон ашиглагч нь тухайн тэмдэг, түүнтэй төсөөтэй тэмдгийг хууль бусаар ашигласны улмаас учирсан хохирлыг

арилгуулахыг шаардах эрхтэй.

13 дугаар зүйл. Гэрчлэх тэмдэг

13.1. Тухайн барааны тэмдгийг гэрчлэх тэмдгээр бүртгүүлэх хүсэлтэй этгээд гэрчлэх тэмдгийн мэдүүлгийг энэ хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу гаргах бөгөөд түүнд дараахь зүйлийг хавсаргана:

13.1.1. гэрчлэх тэмдгийг ашиглах журам;

13.1.2. гэрчлэх байгууллага төн болохыг нотолсон баримт бичиг.

13.2 Гэрчлэх тэмдгийг ашиглах журмд тухайн гэрчлэх байгууллагын нэр, хаяг, гэрчлэх бараа, үйлчилгээний чанар, стандарт, үзүүдэлт, тууд ололт шинж чанарын шаардлага, тухайн зэрэг үйлчилгээг гэрчлэх журам, гэрчлэх тэмдгийг ашиглах нөхцөл, ашиглахад тавих шаардлага, хяналт, өөр юуригоор тэмдгийг ашигласан тохиолдолд хүлээх хариуцлагыг тусгана.

13.3 Гэрчлэх тэмдэг эзэмшигч нь тухайн бараа, үйлчилгээний онцлог шинж чанарыг гэрчлэх байгууллага байх бөгөөд зөвшөөрөл авсан ирэн, хуулийн этгээд гэрчлэх тэмдгийг зөвхөн ашиглах эрхтэй байна.

13.4 Гэрчлэх тэмдгийг ашиглах эрхтэй этгээд нь уг тэмдгийг бусад этгээд хууль бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах эрхтэй бөгөөд ингэхдээ эзэмшигчийн зөвшөөрлийг авна.

13.5 Гэрчлэх тэмдэг эзэмшигч нь гэрчлэх тэмдгийг ашиглах эрхтэй этгээдийн өмнөөс тухайн тэмдэг, түүнтэй төсөөтэй тэмдгийг бусад этгээд хууль бусаар ашигласны улмаас учирсан хохирлыг арилгуулахыг шаардах эрхтэй.

13.6 Гэрчлэх тэмдэг нь газар зүйн заалтаас бүрдсэн бөгөөд барааны гарал үүслийг гэрчилж байвал уг тэмдэгт энэ хуулийн газар зүйн заалтыг хамгаалахтай холбогдсон заалтууд нэгэн адил хамаарна.

14 дүгээр зүйл. Хамтын тэмдэг, гэрчлэх тэмдгийн мэдүүлэгт шүүлт хийх, гэрчилгээ олгох

14.1. Хамтын тэмдэг, гэрчлэх тэмдгийн мэдүүлэгт шүүлт хийх, бүртгэх, гэрчилгээ олгоход энэ хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.

14.2. Оюуны өмчийн байгууллага нь хамтын тэмдэг, гэрчлэх тэмдгийн ном зүйг тэдгээрийг ашиглах журмын хамт хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд нийтлэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Газар зүйн заалт, түүнийг бүртгэх, гэрчилгээ олгох

15 дугаар зүйл. Газар зүйн заалт, түүнд тавих шаардлага

¹ Улсын тэмдэгийн хураамжийн хууль. "Төрийн мэдээлэл" эмгэгний 1993 оны 4, 5 дугаарт нийтлэгдсэн.

15.1. Барааны гарал үүслийг тодорхойлсон тухайн газар нутгийн нэрийг газар зүйн заалтаар бүртгэнэ.

15.2. Дараах зүйлийг газар зүйн заалтад тооцогүй

15.2.1. энэ хуулийн 3.1.4-т заасан тодорхойлолтод зааарахгүй бол;

15.2.2. үйлдвэрлэсэн газраас үл хамааран Монгол Улсын нутаг дэвсгэрт тухайн төрлийн барааны өрнөхий эр болсон бол

15.3. Дараах газар зүйн заалтыг бүртгэхгүй:

15.3.1. Монгол Улсад бүртгэгдсэн адил бараанд хэрэглэх газар зүйн заалт буюу барааны тэмдэгтэй ижил бол;

15.3.2. Монгол Улсад бүртгэгдсэн нэг төрлийн бараанд хэрэглэх газар зүйн заалт, барааны тэмдэгтэй ижил буюу төсөвтэйгээс хэрэглэгчийг төөргөлдд оруулж болзошгүй бол;

15.3.3. барааны төрөл, бүртгэгдсэн эсэхээс үл хамаарч нийтэд түгээмэл болсон барааны тэмдэгтэй ижил буюу төсөвтэйгээс хэрэглэгчийг төөргөлдд оруулах, шударга бус давуу эрх эдлэх, ашиг олж, хохисол учруулах, нэр хүндийг гутаахаар бол.

16 дугаар зүйл. Газар зүйн заалтын мэдүүлэг гаргах

16.1. Тухайн газар нутагт түүнээс хамаарах онцлог шинэ чанартай бараа үйлдвэрлэдэг иргэн, хуулийн этгээд нь газар зүйн заалтыг бүртгүүлэх мэдүүлгийг оюуны өмчийн байгууллагад гаргах бөгөөд мэдүүлэгт дараах зүйлийг тусгана.

16.1.1. газар зүйн заалт бүртгүүлэх тухай хүсэлт;

16.1.2. мэдүүлэг гаргагчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хаяг, харьяалал, байнга оршин суудаг буюу үйлдвэрлэл явуулдаг улсын нэр;

16.1.3. мэдүүлэг гаргагч хуулийн этгээд бол түүний оноосон нэр, хаяг, зохион байгуулалтын хэлбар;

16.1.4. мэдүүлэг гаргагч итгэмжлэгдсэн гөлөөлөгчтэй байвал түүний овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хаяг;

16.1.5. газар зүйн заалтын нэр;

16.1.6. тухайн газар нутгийн газар зүйн байршил;

16.1.7. барааны нэр;

16.1.8. барааны онцлог шинэ чанарын тодорхойлолт болон газар зүйн нөхцөл, хүмүүсийн дадал заншилтай хархэн холбогдсон тухай тайлбар.

16.2. Газар зүйн заалтын мэдүүлэгт дараах зүйлийг хавсаргана:

16.2.1. тухайн газар нутагт үйлдвэрлэл эрхэлдгийг нотолсон аймаг, нийслэлийн

Засаг даргын Тамгын газрын тодорхойлолт;

16.2.2. мэдүүлгийг гадаадын иргэн, хуулийн этгээд гаргаж байгаа бол тухайн газар зүйн заалтыг уг бараа анх үүссэн, эсхүл анх үйлдвэрлэгдсэн улс, бүс, газар нутагт хамгаалагдсаныг нотолсон баримт;

16.2.3. мэдүүлгийг дотоодын хуулийн этгээд гаргаж байгаа бол улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчүүлсэн хуулбар.

16.3. Газар зүйн заалтын мэдүүлгийг хэд хэдэн этгээд хамтран гаргаж болно.

16.4. Газар зүйн заалтыг энэ хуульд заасан журмын дагуу бүртгүүлсэн Монгол Улсын иргэн, хуулийн этгээд гадаад оронд уг газар зүйн заалтад эрхийн хамгаалалт хүсч байгаа тохиолдолд тухайн орны хууль тогтоомжийн дагуу эрхийн хамгаалалт эдэлнэ.

17 дугаар зүйл. Газар зүйн заалтын мэдүүлгийн анхдагч оноог тогтоох, шүүлт хийх

17.1. Газар зүйн заалтын мэдүүлгийн анхдагч оноог тогтоох, уг мэдүүлэгт шүүлт хийхдээ энэ хуулийн 7, 8 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

18 дугаар зүйл. Газар зүйн заалтыг бүртгэх, гэрчилгээ олгох

18.1. Оюуны өмчийн байгууллага нь газар зүйн заалтыг бүртгэх шийдвэр гаргасан бол түүнийг газар зүйн заалтын улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгож, мэдүүлгийг нь газар зүйн заалтын санд хадгална.

18.2. Газар зүйн заалтын улсын бүртгэл болон гэрчилгээнд газар зүйн заалт хэрэглэгчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээдийн оноосон нэр, хаяг, газар зүйн заалтын нэр, онцлог шинэ чанар, барааны нэр, гэрчилгээ олгох тухай шийдвэрийн дугаар, оноо, мэдүүлгийн анхдагч оноог заана.

18.3. Газар зүйн заалтын бүртгэлийн хураамжийг энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу тална.

18.4. Газар зүйн заалтын бүртгэл нь мэдүүлгийн анхдагч онооноос эхлэн хүчинтэй байх бөгөөд тодорхой хугацаагаар хязгаарлагдахгүй.

18.5. Оюуны өмчийн байгууллага нь газар зүйн заалтын нэр, ном зүйг хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд нийтэлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Барааны тэмдэг эзэмшигч, газар зүйн заалт хэрэглэгчийн эрх, барааны тэмдэг, газар зүйн заалтыг ашиглах

19 дүгээр зүйл. Барааны тэмдэг эзэмшигчийн эрх

19.1. Бүртгэгдсэн барааны тэмдэг эзэмшигч нь

тухайн тэмдгийн хувьд дараахь онцгой эрх эдэлнэ:

19.1.1. бүртгэгдсэн тэмдгээ өмчлөх / эзэмших, ашиглах, захиран зарцуулах;

19.1.2. өөрийн бараа, үйлчилгээнд бүртгэгдсэн тэмдгийг ашиглах;

19.1.3. тэмдгийг бусдад лицензийн гэрээгээр ашигуулах;

19.1.4. барааны тэмдгийг бусдад шилжүүлэх;

19.1.5. бүртгэгдсэн тэмдгийн талаар оюуны өмчийн байгууллагаас лавлагаа, нотолгоо гаргуулж авах;

19.1.6. бүртгэгдсэн тэмдгийг бусад этгээд хууль бусаар ашиглаж эрхийг нь зөрчсөн бол уг үйлдлийг таслан зогсоох, зөрчигдсэн эрхээ хамгаалуулахаар шаардах;

19.1.7. бүртгэгдсэн тэмдэгтэй ижил буюу төсөөтэй тэмдгийг бусад этгээд ашиглахыг зогсоох, учруулсан хохирлыг арилгуулахыг шаардах.

19.2. Энэ хуулийн 19.1.7-д заасан эрх нь бүртгэгдсэн барааны тэмдгийн анхдагч огнооноос өмнө түүнтэй ижил тэмдгийг адил бараа, үйлчилгээнд хэрэглэж байсан этгээдийн эрхийг хөндөхгүй.

19.3. Барааны тэмдэг эзэмшигчийн онцгой эрх нь уг тэмдгийг бүртгүүлсэн бараа, үйлчилгээний жагсаалтын хүрээнд үйлчилнэ.

20 дугаар зүйл. Барааны тэмдгийг ашиглах

20.1. Дараахь үйлдлийг барааны тэмдэг ашигласан гэж үзнэ

20.1.1. барааны тэмдгийг бараа, түүний сав, баглаа боодол, үйлчилгээнд хэрэглэсэн;

20.1.2. барааны тэмдэг бүхий барааг нийлүүлсэн, худалдаанд гаргасан буюу энэ зорилгоор хадгалсан, үйлчилгээ үзүүлсэн;

20.1.3. барааны тэмдэг бүхий барааг хилээр нэвтрүүлсэн;

20.1.4. барааны тэмдгийг албан бичиг, танилцуулга, бусад баримт, инженер, сурталчилгаанд ашигласан.

20.2. Барааны тэмдэг эзэмшигч нь барааны тэмдэг бүртгэгдсэнийг илэрхийлэх дугуй хүрээтэй "R" гэсэн латин үсэг бүхий таних тэмдгийг барааны тэмдгийн хамт хэрэглэж болно.

20.3. Бүртгэгдсэн барааны тэмдэг эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр бусад этгээд уг тэмдэгтэй ижил буюу төсөөтэй тэмдгийг адил буюу нэг төрлийн бараа, үйлчилгээнд ашиглавал эзэмшигчийн эрхийг зөрчсөн гэж үзнэ.

21 дүгээр зүйл. Барааны тэмдэг эзэмших эрхийг бусдад шилжүүлэх, барааны тэмдэг эзэмших эрх дуусгавар болох

21.1. Барааны тэмдэг эзэмшигч нь өв

залгамжлал болон бусад хэлбэрээр бараань тэмдэг эзэмших эрхээ бүх буюу зарим бараа, үйлчилгээний хувьд бусдад шилжүүлж болно.

21.2. Барааны тэмдэг эзэмших эрхийг гэрээ байгуулсны үндсэн дээр шилжүүлэх бөгөөд гэрээг бичгээр үйлдэж, хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулах ба талууд хүсвэл гэрээг нотариатаар гэрчилүүлж болно.

21.3. Барааны тэмдэг эзэмших эрхийг бусдад шилжүүлэх гэрээг оюуны өмчийн байгууллагад бүртгүүлэх бөгөөд бүртгүүлснээр эрх шилжсэнд тооцно.

21.4. Барааны тэмдэг эзэмших эрх дараахь үндэслэлээр дуусгавар болно:

21.4.1. хууль буюу ирээгээр бусдад бүрэн шилжүүлсэн;

21.4.2. эзэмшигч нь нас барсан буюу нас барсан гэж зарлагдсан;

21.4.3. хуулийн этгээд татан буугдсан бөгөөд эрх нь бусдад шилжээгүй;

21.4.4. хуульд заасан бусад үндэслэл.

22 дугаар зүйл. Лицензийн гэрээ

22.1. Сонирхогч этгээд эзэмшигчтэй нь лицензийн гэрээ байгуулан барааны тэмдгийг бүх буюу зарим бараа, үйлчилгээний хувьд ашиглах болох бөгөөд уг гэрээг оюуны өмчийн байгууллагад бүртгүүлснээр хүчингэйд тооцно.

22.2. Лицензийн гэрээнд дараахь зүйлийг тусгана:

22.2.1. барааны тэмдгийг ашиглах хэлбэр, хүрээ, хугацаа, холбогдох бараа, үйлчилгээнд тавих чанарын шаардлага, хяналт;

22.2.2. талуудын эрх, үүрэг;

22.2.3. барааны тэмдэг ашигласны төлөө төлөх төлбөрийн хэмжээ, түүнийг төлөх журам;

22.2.4. гэрээ үйлчлэх нутаг дэвсгэрийн хүрээ.

22.3. Лицензийн гэрээг бүртгүүлэхдээ Улсын тэмдэгтийн хураамжийн хуульд заасан хувь хэмжээгээр хураамж төлнө.

23 дугаар зүйл. Газар зүйн заалт хэрэглэгчийн эрх

23.1. Газар зүйн заалт хэрэглэгч нь дараахь эрх эдэлнэ:

23.1.1. өөрийн бараанд газар зүйн заалтыг ашиглах;

23.1.2. газар зүйн заалтын талаар оюуны өмчийн байгууллагаас лавлагаа, нотолгоо гаргуулж

авах

23.1.3 бүртгэгдсэн газар зүйн заалтыг бусад этгээд тухайн газар нутагт үйлдвэрлээгүй бараанд хэрэгцээгээс барааны гарал үүслийн хувьд төвөгдөлд орууж болзошгүй бол уг үйлдлийг таслан зогсоох, зөрчигдсөн эрхээ хамгаалуулах, хохирлыг арилгулахыг шаардах;

23.1.4 бүртгэгдсэн газар зүйн заалтыг бусад этгээд нэг төрлийн бараанд хэрэгцээгээс шударга бус давуу эрх эдлэх буюу газар зүйн заалтын нэр хүндийг гутаахар бол уг үйлдлийг таслан зогсоох, зөрчигдсөн эрхээ хамгаалуулах, хохирлыг арилгуулахыг шаардах.

24 дүгээр зүйл. Газар зүйн заалтыг ашиглах

24.1 Дараахь үйлдлийг газар зүйн заалтыг ашигласан гэж үзнэ.

24.1.1 газар зүйн заалтыг бараа түүийсав, багнаа боодолд хэрэглэсэн;

24.1.2 газар зүйн заалт бүхий барааг хиллэг нэвтрүүлсэн;

24.1.3 тухайн бараатай холбоотой үйл ажиллагаанд хэрэглэгдэх албан бичиг, танилцуулга, бүсд заримт, интернэт, сурталчилгаанд ашигласан.

24.2 Газар зүйн заалтыг зөвхөн түүнийг бүртүүлсэн этгээд өөрийн үйлдвэрлэлдээ ашиглах эрхээ бөгөөд байнга оршин суугаа газар нь уг үйлдвэрлэл эрхлэх газар нутаг байна.

24.3 Бүртгэгдсэн газар зүйн заалтад хамаарах газар нутагт үйл ажиллагаа явуулдаг, газар зүйн заалтыг бүртгүүлэхээс өмнө мэдүүлэгт дурдсан барааг төгмөл үйлдвэрлэж байсан этгээд уг газар зүйн заалтыг үргэлжлүүлэн ашиглах эрх эдэлнэ.

25 дугаар зүйл. Газар зүйн заалтын бүртгэлийн хүчинтэй байх хугацаа дуусгавар болох

25.1 Газар зүйн заалтын бүртгэлийн хүчинтэй байх хугацаа нь гэгцхүү тухайн барааны онцлог шинж чанар нь тухайн газар зүйн нөхцөл, хүмүүсийн дадал заншилтай шууд холбоогүй болсон тохиолдолд дуусавар болно.

ТАВДУГААР БҮЛЭГ

Барааны тэмдгийн олон улсын бүртгэл

26 дугаар зүйл. Барааны тэмдгийн олон улсын бүртгэл

26.1 Монгол Улсын нэр заасан барааны тэмдгийн олон улсын бүртгэл нь Монгол Улсад мэдүүлгийг шууд хүлээн авах, шүүлт хийх, бүртгэх жамтгай нэгэн ажил байх бөгөөд харин аяндагч онгоор олон улсын бүртгэлийн огноогоор, эсхүл нутаг дэвсгэрийн хүрээг нэмэгдүүлэх тухай хүсэлтийн өмчлөгч тогтооно.

26.2 Монгол Улсад улсын бүртгэлд бүртгэгдсэн барааны тэмдэг эзэмшигч уг тэмдэг олон

улсын бүртгэлд бүртгүүлсэн бол үндэсний бүртгэлээс татгалзах тухай хүсэлтээ оюуны өмчийн байгууллагад гаргаж болно.

27 дугаар зүйл. Дотоодын тэмдгийг олон улсын бүртгэлд бүртгүүлэх

27.1 Энэ хуульд заасан журмын дагуу барааны тэмдгээ бүртгүүлсэн буюу бүртгүүлэхээр мэдүүлсэн Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, түүнчлэн Монгол Улсад үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг болон байнга оршин суудаг аливаа этгээд уг тэмдгээ олон улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлтэй бол барааны тэмдгийн олон улсын мэдүүлгийг оюуны өмчийн байгууллагаар дамжуулан Дэлхийн оюуны өмчийн байгууллагын Олон улсын товчоо /цаашид "Олон улсын товчоо" гэх/-нд гаргана.

27.2 Барааны тэмдгийн олон улсын мэдүүлгийг Мадридын хэлэлцээр болон Мадридын Протоколд заасан шаардлагын дагуу бүрдүүлнэ.

27.3 Мэдүүлэг гаргагч нь барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн хугацааг сунгуулах, барааны тэмдэг эзэмшигчийн эрх шийгжүүлэх, хүчингүй болгох, нутаг дэвсгэрийн хүрээг нэмэгдүүлэх тухай хүсэлтийг оюуны өмчийн байгууллагаар дамжуулан Олон улсын товчоонд гаргана.

27.4 Мэдүүлэг гаргагч нь барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн хураамжийг Мадридын хэлэлцээр болон Мадридын Протоколын Нийтлэг журамд заасны дагуу Олон улсын товчоонд төлнө.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

28 дугаар зүйл. Барааны тэмдэг, газар зүйн заалтын бүртгэлийг хүчингүй болгох, хүчингүй болсонд тооцох

28.1 Сонирхогч этгээд энэ хуулийн 5.2, 5.3, 5.4-т заасныг зөрчиж барааны тэмдгийг, 15.2, 15.3-т заасныг зөрчиж газар зүйн заалтыг бүртгэсэн гэж үзвэл уг тэмдэг, газар зүйн заалтын бүртгэлийг хүчингүй болгох тухай хүсэлтээ шүүхэд гаргаж болно.

28.2 Шүүх үндэслэлтэй гэж үзвэл барааны тэмдэг, газар зүйн заалтын бүртгэлийг хүчингүй болгох тухай шийдвэр гаргаж, энэ тухай оюуны өмчийн байгууллагад мэдэгдэнэ.

28.3 Оюуны өмчийн байгууллага дараахь тохиолдолд өмнө бүртгэсэн барааны тэмдэг, газар зүйн заалтын бүртгэлийг тухайн эзэмшигч, хэрэглэгчийн хувьд хүчингүй болсонд тооцно.

28.3.1 барааны тэмдгийн гэрчилгээний хүчинтэй байх хугацаа дууссанаас хойш 6 сарын дотор хугацаа сунгуулах тухай хүсэлт гаргаагүй;

28.3.2 барааны тэмдэг эзэмшигч, газар зүйн заалт хэрэглэгч нь бүртгэгдсэн барааны

тэмдгийг эзэмших, газар зүйн заалтыг хэрэглэх эрхээсээ татгалзсан тухай бичгээр мэдэгдсэн,

28.3.3. барааны тэмдэг эзэмшигч, газар зүйн заалт хэрэглэгч хуулийн этгээд татан буугдсан бөгөөд уг барааны тэмдгийг эзэмших, газар зүйн заалтыг хэрэглэх эрхийг өөр этгээдэд шилжүүлээгүй буюу барааны тэмдгийг лицензийн гэрээгээр ашиглуулаагүй,

28.3.4. барааны тэмдэг эзэмшигч, газар зүйн заалт хэрэглэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр барааны тэмдгийг 5 жилийн турш ашиглаагүй,

28.3.5. газар зүйн заалт нь тухайн барааны ерөнхий нэр болсон.

28.4. Барааны тэмдэг, газар зүйн заалтын бүртгэлийг хүчингүй болсонд тооцсон шийдвэрийг эс зөвшөөрвөл сонирхогч этгээд энэ тухай гомдлоо шийдвэрийг хүлээн авснаас хойш 2 сарын дотор шүүхэд гаргах эрхтэй.

28.5. Сонирхогч этгээд энэ хуулийн 28.3.4-т заасан үндэслэлээр барааны тэмдгийн бүртгэлийг хүчингүй болсонд тооцох тухай хүсэлтийг оюуны өмчийн байгууллагад гаргаж болно.

28.6. Барааны тэмдэг, газар зүйн заалтын бүртгэлийг хүчингүй болгосон, эсхүл хүчингүй болсонд тооцсон тохиолдолд оюуны өмчийн байгууллага нь барааны тэмдэг, газар зүйн заалтын улсын бүртгэлд зохих өөрчлөлт оруулж, энэ тухай хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд нийтэлнэ.

29 дүгээр зүйл. Гомдол, маргааныг шийдвэрлэх

29.1. Оюуны өмчийн байгууллага нь барааны тэмдэг, газар зүйн заалтын талаар гарсан дараахь гомдол, маргааныг хянан шийдвэрлэнэ.

29.1.1. барааны тэмдэг, газар зүйн заалтын мэдүүлэгт шүүлт хийхтэй холбогдсон,

29.1.2. анхдагч ба давамгайлах огноо тогтоохтой холбогдсон,

29.1.3. барааны тэмдэг, газар зүйн заалтын улсын бүртгэлтэй холбогдсон.

29.2. Оюуны өмчийн байгууллага нь гомдол, өргөдлийг хүлээж авснаас хойш 1 сарын дотор хянан шийдвэрлэж, хариу мэдэгдэх үүрэгтэй.

29.3. Маргааныг хянан шийдвэрлэсэн оюуны өмчийн байгууллагын шийдвэрийг эс зөвшөөрвөл маргагч талууд шийдвэрийг хүлээн авснаас хойш 2 сарын дотор гомдлоо шүүхэд гаргах эрхтэй.

29.4. Оюуны өмчийн байгууллагад хуулиар харъяалуулснаас бусад гомдлоо, маргааныг шүүх хүлээн авч шийдвэрлэнэ.

30 дугаар зүйл. Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

30.1. Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол оюуны өмчийн хяналтын улсын байцаагч зөрчил гаргасан иргэнийг 50000 хүртэл, аж ахуйн нэгж, байгууллагыг 250000 хүртэл төгрөгөөр торгох, шүүгч иргэнийг 50000 хүртэл төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 250000 хүртэл төгрөгөөр торгож, барааны тэмдэг, газар зүйн заалтыг хууль бусаар ашигласнаас олсон орлогыг барааны тэмдэг эзэмшигч, газар зүйн заалт хэрэглэгчид олгох буюу барааг худалдсанаас олсон орлогыг улсын орлого болгож, үйлдвэрлэл, үйлчилгээг нь зогсооно.

30.2. Барааны тэмдэг эзэмшигч, газар зүйн заалт хэрэглэгчийн эрхийг зөрчсөнөөс учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлөх асуудлыг Иргэний хуулийн дагуу шийдвэрлэнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДСРХ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

БАРААНЫ ТЭМДЭГ, АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРИЙН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1996 оны 12 дугаар сарын 19-ний өдөр батлагдсан Барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийн тухай хуулийг хүчингүй болгонд тооцугай.

газар зүйн заалтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДСРХ

2 дугаар зүйл. Энэ хуулийг Барааны тэмдэг,

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн хуулийн 5 дугаар зүйлийн 11 дэх заалт, 16 дугаар зүйлийн "барааны тэмдэгт гэрчилгээ олгох" гэснийг "барааны тэмдэг, газар зүйн заалтад гэрчилгээ олгох", 16 дугаар зүйлийн 2 дахь заалтын "барааны тэмдгийг бүртгэж" гэснийг "барааны тэмдэг, газар зүйн заалтыг бүртгэж" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭДДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

"2. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий цагдаагийн алба хаагчид алба хаасан 2 жил тутам ажлын 3 өдрийн, цагдаагийн бусад алба хаагчид алба хаасан 5 жил тутам ажлын 3 өдрийн нэмэгдэл амралт олгоно."

2 дугаар зүйл. Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 11 дэх хэсгийн "тэтгэмжийн зөрүү" гэснийг "тэтгэмж"; мөн хэсгийн 3 дахь заалтын "хохирогчийн авч байсан цалингийн зөрүү" гэснийг "төрөөс 5 жилийн цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тэтгэмж" гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭДДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Захиргааны хариуцлагын тухай хуулийн 25 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 6, 7 дахь хэсэг нэмсүгэй.

"6. Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй этгээд согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон тохиолдолд 7-30 хоног баривчлах шийтгэл ногдуулна."

7. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол иргэнийг 5000-30000, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-200000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна."

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭДДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар 102

Улаанбаатар хот

Амьсгалын цочмог халтай хамшинж өвчний цагийн байдалтай холбогдуулан авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

чиглэлийн төмөр замын дагуух сумдад тогтоосон иргэний хамгаалалтын өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2003 оны 5 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл сунгасугай.

1. Нийслэлийн төрийн захиргааны болон холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хамгаалалтын алба болон Дорноговь, Төв, Говьсүмбэр аймгийн Улаанбаатар-Замын-Үүдийн

2. Хууль зүй, дотоод хэргийн сайд

Ц.Нямдорж, Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун, Дад бүтцийн сайд Б.Жигжид, Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр нарт даалгах нь:

а/ амьсгалын цочмог халтай хамшинж өвчний голомт бүхий Азийн орнуудаас болон эдгээр орноор дамжин Монгол Улсад хөдөлмөр эрхлэхээр виз авсан гадаадын иргэдийг иргэний хамгаалалтын өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд Монгол Улсад нэвтрүүлэхийг зогсоосугай;

б/ 2003 оны 4 дүгээр сарын 13-ны өдрөөс хойш Монгол Улсад хөдөлмөр эрхлэхээр ирсэн гадаадын иргэдийн оршин суугаа хаяг, ажлын байрыг тодруулж, тэдний ажиллаж байгаа газарт эмч томилон орон нутгийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллуулсугай.

3. Иргэний хамгаалалтын өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд дор дурдсан арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа, Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Улсын мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Батбаатар, Дорноговь аймгийн Засаг дарга Ж.Батсуурь нарт үүрэг болгосугай.

а/ Замын-Үүд-Улаанбаатар, Эрээн-Улаанбаатарын галт тэргэнд болон Буянт-Ухаагийн боомтоор улсын хил нэвтрэн ирж байгаа иргэдэд тавих эрүүл мэндийн хяналтыг чангатгаж, уг өвчин

халдварлахаас сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх;

б/ Замын-Үүд, Буянт-Ухаагийн боомтоор ирж байгаа хүн бүрийг нарийвчлан бүртгэж, сэжиг илэрсэн хүнийг Замын-Үүд Сайншандын нэгдсэн эмнэлгийн тусгайлан бэлтгэсэн тасаг, Халдварт өвчин судлалын үндэсний төвд тусгаарлан, нутгийн гүнд халдварын сэжигтэй хүн орохыг хязгаарлах ажилд хяналт тавьж, дэмжлэг үзүүлэх.

4. Иргэний хамгаалалтын бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд Хөх хот-Улаанбаатарын хоорондын агаарын болон төмөр замын хөдөлгөөнийг зогсоосугай.

5. Монгол Улсад хөдөлмөр эрхлүүлэхээр гадаадын иргэдэд шинээр зөвшөөрөл олгохыг иргэний хамгаалалтын өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд зогсоохыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаярт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	Н.ЭНХБАЯР
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	П.НЯМДАВАА
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	Ж.ГҮРРАГЧАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

Дугаар 103

Улаанбаатар хот

Аргачлал, үнэлгээ батлах тухай

Газрын тухай хуулийн 24.3, 58.8-д болон Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 9.1.3-г заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООЛ нь:

"Үнэлгээ батлах тухай" Засгийн газрын 1998 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 119 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

1. "Газар зохион байгуулалтын ажлын үнэлгээ"-г 1 дүгээр хавсралт, "Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх ажлын үнэлгээ"-г 2 дугаар хавсралт, "Иргэнд өмчлүүлэх газрын үнэлгээний аргачлал"-ыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	Н.ЭНХБАЯР
------------------------------	-----------

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	Ө.ЭНХТҮВШИН
--	-------------

Засгийн газрын 2003 оны 103 дугаар
тогтоолын 1 дүгээр хэвсрэлт

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ҮНЭЛГЭЭ

№	Ажлын нэр, /хэмжих нэгж/	Үе шат	Ажлын зэрэглэл	Үнэлгээ /төг/
1	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг тогтоох, тодотгох (1000 га)	1.Бэлтгэл ажлыг хангах 15%	I П Ш	60,0 70,0 80,0
		2. Хээрийн судалгааны ажил 50%	I П Ш	580 680 810
		3. Материал боловсруулалтын ажил 35%	I П Ш	250 302 340
2	Улсын тусгай хэрэгцээний газрын заагийг тогтоох, тодотгох (1000 га)	1.Бэлтгэл ажлыг хангах 15%	I П Ш	48 56 64
		2.Хээрийн судалгааны ажил 50%	I П Ш	464 544 648
		3.Материал боловсруулалтын ажил 35%	I П Ш	200 242 272
3	Хуульд заасны дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах газрын судалгааг хийж хэмжилт, бүртгэл, зураглал үйлдэх, тэдгээрийн хил, заагийг тогтоох, тодотгох (1м ²)	-	-	5.14
4	Улс, бүс нутгийн хэмжээгээр ашиглах, хамгаалах газрын хэтийн төлвийг тогтоож, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нутаг дэвсгэрт болон газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн газарт газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах (1000 га)	1.Бэлтгэл ажлыг хангах 20%	I П Ш	130 140 150
		2. Хээрийн судалгааны ажил 30%	I П Ш	1000 1320 1520
		3. Материал боловсруулалтын ажил 50%	I П Ш	1000 1160 1320
5	Газрын нэгдмэл сангийн ангилал тогтоох (1000 га)	1.Бэлтгэл ажлыг хангах 15%	I П Ш	54 80 98
		2. Хээрийн судалгааны ажил 35%	I П Ш	140 190 240
		3. Материал боловсруулалтын ажил 50%	I П Ш	250 270 310

Засгийн газрын 2003 оны ТУЗ дугаар тогтоолын 2 дугаар хэсэрт

ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН УЛСЫН ХЯНАН БАТАЛГАА ХИЙХ АЖЛЫН ҮНЭЛГЭЭ

Газрын сангийн үүндсэн ангилал, төрөл	Хэмжих нэгж	Нэг хүн өдрийн норматив /га/				Нэгж зардал шинжилгээний зардал /төг/				1000 га болон 10 нэгж талбарын зардал /төг/			
		Бэлтгэл	Хөөрийн ажил	Материал боловсруулалт	Хөрс, ургамлын	Хөрсний бохирдолт	Бэлтгэл	Хээрийн ажил	Материал боловсруулалт	Задлан шинжилгээний	БҮГД		
1.0. Хөдөө аж ахуйн газар													
1.1. Бэлчээр													
1.1.1. Уулархаг бүс	га	37500	7130	10435	8000		80.0	6732.5	287.5	400.0	7500.0		
1.1.2. Тал хээрийн бүс	га	56250	10594	15652	8000		53.3	4488.3	191.7	266.7	5000.0		
1.1.3. Говийн бүс	га	70313	13368	19565	8000		42.7	3590.7	153.3	213.3	4000.0		
1.2. Хадлан													
1.2.1. Уулархаг бүс	га	15097	2870	4201	8000		198.7	16723.5	714.2	993.6	18630.0		
1.2.2. Тал хээрийн бүс	га	18122	3445	5043	8000		165.5	13931.8	594.9	827.7	15520.0		
1.2.3. Говийн бүс	талбарын тоо	20	10	20	8000		1000.0	44500.0	1000.0	1000.0	47500.0		
1.3. Тариалан													
1.3.1. Тариалангийн талбай	га	1539	359	428	8000		1948.8	13374.7	7003.5	40000.0	182700.0		
1.3.2. Төмс, ногооны талбай	талбарын тоо	5000	708	600	8000		600.0	67810.0	5000.0	8000.0	81410.0		
1.4. Атаржсан газар													
1.5. Жимс, жимсгэний талбай	га	1975	503	550	8000		1518.9	95422.4	5458.7	40000.0	142400.0		
	талбарын тоо	375	53	165	8000		8000.0	90199.7	18133.0	8000.0	936130.0		

1.6. Хөдөө аж ахуйн барилга, байгууламжийн газар	талбарын тоо	20	10	20			1000.0	1000.0	45500.0	47500.0
1.7.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээний бусад газар	талбарын тоо	20	10	20			1000.0	1000.0	45500.0	47500.0
2.0.Хөт тосгон, бусад суурин газар										
2.1.Барилга, байгууламжийн дэвсгэр, түүний ор-мын газар	талбарын тоо	20	16	20			1200.0	1000.0	26440.0	31640.0
2.2.Нийтийн эзлэлтийн газар	талбарын тоо	24	12	24	5000	32914.0	833.0	32914.0	2033.0	5000.0
2.3.Үйлдвэрлэлийн газар	талбарын тоо	6	3	6	5000	126664.0	3333.0	126664.0	9333.0	25000.0
2.4.Уурхайн газар	талбарын тоо	4	2	4	5000	211500.0	5000.0	211500.0	13400.0	254900.0
2.5.Гэр хорооллын газар	хашааны тоо	20	10	20	5000	40500.0	1000.0	40500.0	2200.0	5000.0
2.6.Бусад газар	талбарын тоо	16	8	16	5000	51800.0	1250.0	51800.0	2450.0	5000.0
3.0.Зам, шугам сүлжээний газар										
3.1.Төмөр зам	талбарын тоо	20	10	20			1000.0	45500.0	1000.0	47500.0
3.2.Авто зам	талбарын тоо	16	8	16			1250.0	56880.0	1250.0	59380.0
3.3.Агаарын тээврийн түүний орчмын газар	талбарын тоо	20	10	20			1000.0	45500.0	1000.0	47500.0
3.4.Усан тээврийн зогсоол	талбарын тоо	20	10	20			1000.0	45500.0	1000.0	47500.0
3.5.Шугам сүлжээний газар	талбарын тоо	15	8	16			1250.0	56880.0	1250.0	59380.0
3.6.Бусад газар	талбарын тоо	16	9	18			1111.0	50558.0	1111.0	52780.0
4.0.Ойн сан бүхий газар										
4.1.Ойгоор бүрхэгдсэн газар	га	6000	1277	3750			500.0	37600.0	800.0	38900.0
4.2.Мод үржүүлгийн газар	га	3750	844	3601			800.0	56875.0	833.0	56508.0
4.3.Ой модрыг нь огтлоон газар	га	3000	422	1801			1000.0	113754.0	1066.0	116420.0
4.4.Ойн сангийн бусад	талбарын тоо	18	9	16			1111.0	50558.0	1111.0	52780.0

ИРГЭНД ӨМЧЛҮҮЛЭХ ГАЗРЫН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

1. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан зориулалтаар иргэнд өмчлүүлэх газрын үнийг тодорхойлоход энэхүү аргачлалыг мөрдөнө.

2. Энэхүү аргачлалаар тодорхойлсон үнэ нь иргэнд өмчлүүлэх газрын худалдах үнэ, дуудлага худалдааны журмаар өмчлүүлэх тохиолдолд дуудлагын худалдааны доод үнэ байна.

3. Иргэнд өмчлүүлэх газрын үнийг газар ашиглалтын үндсэн зориулалтаас нь шалтгаалан дараахь байдлаар тодорхойлно:

3.1. гэр бүлийн хэрэгцээний болон газар тариалангийнхаас бусад аж ахуйн зориулалтаар өмчлүүлэх газрын үнэ;

3.2. газар тариалангийн зориулалтаар өмчлүүлэх газрын үнэ.

4. Гэр бүлийн хэрэгцээний болон газар тариалангийнхаас бусад аж ахуйн зориулалтаар өмчлүүлэх газрын үнийг тодорхойлоход дараахь зарчмыг баримтална:

4.1. гэр бүлийн хэрэгцээний болон газар тариалангийнхаас бусад аж ахуйн зориулалтаар өмчлүүлэх газар нь тухайн хот, тосгон, бусад суурины газрын аль зэрэглэлд хамаарагдаж байгаа, ямар суурь үнэлгээтэйг "Газрын төлбөрийн хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1997 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 152 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг үндэслэн тогтооно;

4.2. гэр бүлийн хэрэгцээний болон газар тариалангийнхаас бусад аж ахуйн зориулалтаар өмчлүүлэх газрын үнийг тодорхойлохдоо хот, тосгон, бусад суурин газрын газрын суурь үнэлгээ, байршил, инженерийн хангамж, нийгэм, эдийн засгийн болон байгаль, экологийн нөхцөлийг харгалзан үзнэ;

4.3. энэ аргачиллын 4.2-т заасан ялгаварт нөхцөлийг дор дурдсан итгэлцүүрээр илэрхийлэх бөгөөд итгэлцүүрийг хэрэглэхдээ төвөөс гадагшлах тутам буурах зарчмыг баримтална:

4.3.1. нийслэл, улсын зэрэглэлтэй хотод 1,0-0,3;

4.3.2. аймгийн зэрэглэлтэй хотод 1,0-0,5;

4.3.3. сумдын төв, бусад суурин 1,0-0,6.

4.4. Газрын төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон итгэлцүүрийг хэрэглэх газрын зааг, хязгаар энэ аргачиллын 4.3-т заасан итгэлцүүрийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга иргэнд өмчлүүлэх газрын үнийг тогтооно.

Жишээлбэл, Улаанбаатар хотын инженерийн шугам сүлжээ, зам харилцаанаас алслагдсан газарт иргэн гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 700 м² газрыг өмчилж авахаар хүсэлт гаргасан гэж үзээд уг газрын үнийг тодорхойлол:

Энэ тохиолдолд Улаанбаатар хотын 1 м² газрын суурь үнэлгээ болох 44000 төгрөгийг инженерийн шугам сүлжээ, зам харилцаанаас алслагдсан нөхцөлийг харгалзан энэ аргачиллын 4.3.1-д зааснаар 0,3 гэсэн итгэлцүүрээр үржүүлэхэд тухайн бүсийн 1 м² талбайн үнэ 13200 төгрөг болж байна.

Өөрөөр хэлбэл тооцоолсон бүс дэх 700 м² талбайн үнэ нь:

$$13200 \text{ төг} / \text{м}^2 \times 700 \text{ м}^2 = 9240000 \text{ төг} \text{ болно.}$$

5. Газар тариалангийн зориулалтаар өмчлүүлэх газрын үнийг газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгаагаар тогтоогдсон нэгж талбар бүрээр тодорхойлно.

6. Газар тариалангийн зориулалтаар өмчлүүлэх газрын үнийг тодорхойлоход дараахь зарчмыг баримтална:

6.1. газар тариалангийн зориулалтаар өмчлүүлэх газар нь Монгол Улсын газрын нэгдмэл сангийн үнэлгээний тойргийн хуваарийн аль тойрогт хамаарагдах, 1 га тариалангийн газрын суурь үнэлгээг Засгийн газрын 1997 оны 152 дугаар тогтоолын 1, 3 дугаар хавсралтыг үндэслэн тодорхойлно.

6.2. өмчлүүлэх газрын нэгж талбар бүрийн хөрсний шинж чанар, төлөв байдлын Хүснэгт-1-д заасан үзүүлэлт бүрт тохирох итгэлцүүрээр суурь үнэлгээг үржүүлэн 1 га газрын үнийг тооцно.

Хүснэгт-1

№	Хөрсний шинж чанар, төлөв байдал	Үзүүлэлтүүд	Засварлах итгэлцүүр
1	Ялзмаг агууламж /хувиар/	3,0-аас дээш	1,0
		2,0-3,0	0,8
		1,0-2,0	0,6
		0,2-1,0	0,4
2	Ялзмагт үе давхаргын зузаан /см/	30-с дээш	1,0
		25-30	0,9
		16-25	0,8
		10-15	0,7
3	Налуу /хэмээр/	1 ^о -аас бага	1,0
		1-3 ^о	0,9
		3-5 ^о	0,8
		5-7 ^о	0,6
4	Чулуужилтын зэрэг	Бага	0,9
		Дунд	0,8
		Их	0,7
		Маш их	0,6
5	Хөрсний элэгдэл эвдрэлийн зэрэг	Эвдрэлд ороогүй	1,0
		Сул	0,8
		Дунд зэрэг	0,6
		Хүчтэй эвдэрсэн	0,4

Жишээлбэл, Төв аймгийн Өндөрширээт сумын нэг өрх газар тариалангийн зориулалтаар 9/234 нэгж талбарын дугаартай талбайг өмчилж авахаар хүсэлт гаргасан гэж үзээд үнийг нь тодорхойлбол:

а/ Төв аймаг нь Засгийн газрын 1997 оны 152 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад заасны

дагуу газрын үнэлгээний Хангай Хэнтийн уулархаг тойрогт хамаарагдах бөгөөд 3 дугаар хавсралтын дагуу 1 га тариалангийн газрын суурь үнэлгээ 3859000 төгрөг болно;

б/ тухайн нэгж талбарын хөрсний шинж чанар, төлөв байдлын үзүүлэлт бүрээр итгэлцүүрийг сонгон авахад дараахь байдалтай байна:

№	Хөрсний шинж чанар, төлөв байдал	Үзүүлэлтүүд	Засварлах итгэлцүүр
1	Ялзмаг агууламж /хувиар/	1,09	0,6
2	Ялзмагт үе давхаргын зузаан /см/	20	0,8
3	Налуу /хэмээр/	1-3 ^о	0,9
4	Чулуужилтын зэрэг	Бага	0,9
5	Хөрсний элэгдэл эвдрэлийн зэрэг	Дунд зэрэг	0,6

в/тухайн тойргийн 1 га тариалангийн газрын суурь үнэлгээг сонгосон итгэлцүүрүүдээр үржүүлбэл 1 га талбайн үнэ нь:

$3859000 \text{ төг/га} \times 0,6 \times 0,8 \times 0,9 \times 0,9 \times 0,6 = 900227 \text{ төг/га}$ болж байна.

г/өмчлүүлэх тухайн 234 га талбайн үнэ нь нийт:

$900227 \text{ төг/га} \times 234 \text{ га} = 210653118 \text{ төгрөг}$ болно.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргов
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэл хэргийн хэвлэл

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 329612
Индекс: 14003

☎ 329487
Хэвлэлийн хуудас 2